



НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ ИННОВАЦИ

ҮУПК-ИЙН УРИА:

*“ШИНЭ САНААГАА ШАВХАГДАШГҮЙ НӨӨЦ, ХӨГЖЛИЙН
БОЛОМЖ БОЛГОЯ”*



РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

ӨМНӨТГӨЛ

“ХҮН БҮРИЙН БҮТЭЭЛЧ БАЙДАЛ НЬ ХӨГЖИЛ, ДЭВШЛИЙГ БИЙ БОЛГОДОГ”

Хамт олон гэдэг бол сургуулийнхаа хөгжлийн зорилгын төлөө нэгдсэн нэг баг юм. Үйл ажиллагааныхаа чанарын төлөө байнгын ахиц дэвшил гаргаж, шинийг сэдэж, хэрэгжүүлж байдаг. Тиймээс хүн бүрийн бүтээлч үйл ажиллагаа чухал бөгөөд шинэ санаагаа ажил хэрэг болгох нь зорилгынх нь гол хүч, хөдөлгүүр болдог. Өнөөдөр шинжлэх ухааны хөгжил улам бүр хурдтай болж, мэдээллийн технологи, биотехнологи, нанотехнологи хөгжиж байна. Энэ нь бид үйл ажиллагааны инновацид онцгой ач холбогдол өгөх шаардлагатай болсныг харуулж байна. Бид сургуулийнхаа багш, ажилтны бий болгосон шинэ санаа, бүтээлийг энэхүү цахим сэтгүүлээр түгээн дэлгэрүүлж байх болно. Хүн бүр өөрийн үйл ажиллагааг шинэ түвшинд хүргэх бүтээлч санаа гаргаж, санаж, сэтгэж ажиллана гэдэгт итгэж байна. Санаж, сэтгэж байдаг учраас бид хүн байдаг Сайхан сэтгэл, зорилго, ухаан байдаг учраас бид бусдаас ялгардаг.

ИННОВАЦЛАГ ХАМТ ОЛОН БОЛОХЫН ТӨЛӨӨ ХИЧЭЭЦГЭЭ.

Хүндэтгэсэн: Захирал Д.БУЯНДЭЛГЭР

ЦАХИМ СУРГУУЛИЙН СИСТЕМ



2020 он Дэлхийн нийтээрээ Корона вирус “Ковид-19” цар тахалд нэрвэгдэж, Монгол улсад ч энэхүү аюулт өвчин тархсан хүнд цаг үед уламжлалт танхимын сургалтаар боловсрол олгох боломжгүй цаг үед бид амьдарч байна. Энэхүү өвчний тархалтхэээ намдаж, хичээл сургалтхэвийн танхимаар орох нь тодорхойгүй энэ цаг үед бидэнд сургалтын шинэ талбарын хэрэгцээ гарсан. Иймд энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа инноваци, судалгааны ажлыг хийж буй багш Э.Түвшингийн судалгааны бүтээлийг товч танилцуулж байна.

ОВОГ: ЭРДЭНЭБАТ

НЭР: ТҮВШИН

ТӨГССӨН СУРГУУЛЬ, МЭРГЭЖИЛ:

Монгол Улсын Боловсролын Их сургууль КМТС
Мэдээлэл зүйн багш

АЖЛЫН ТУРШЛАГА: 2016 оноос ҮҮПК-д
Мэдээллийн технологийн багшаар 5 дахь жилдээ
багшилж байна

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

2018 цахим хичээлийн улсын уралдаан тусгай
байр, 2020 оны “Оны шилдэг багш”

ЦАХИМ ХАЯГ: tuwshin12@gmail.com

ЦАХИМ СУРГАЛТЫН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН УДИРДЛАГА, ЭЦЭГ ЭХ, СУРАЛЦАГЧДЫГ ХАМАРСАН



Цахим сургуулийн системийг нэвтрүүлэхийн тулд багш, суралцагч эцэг эхээс цахим хэлбэрээр судалгааг авч дүгнэсэн. Судалгааны үр дүнг нэгтгэн харвал:

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, НЭГТГЭЛ

1



Энэхүү судалгаанаас үзэхэд нийт багш нарын 85 хувь нь өөрийн заадаг хичээлийг цахим хэлбэрээр /текст, зураг, видео, анимейшн гэх мэт / бэлтгэж сурагчдад facebook group-д байрлуулсан цахим хичээлийг түгээн байна. а Facebook group-ээр дамжуулан цахим хичээлийг суралцагчдад түгээнээр дараах дутагдалтай талтай юм. Үүнд:

- Цахим хичээлийн сан бүрдэхгүй
- Суралцагчид олон багшийн олон хичээлээс хичээлийг түүж үзэх хүндрэлтэй
- Зарим оруулсан цахим хичээлийг суралцагч үзэхгүй өнгөрөх магадлал өндөр
- Багш тухайн хичээлийг хэн хэн үзсэн байна гэдгийг тооцоход хүндрэлтэй
- Багш хичээлийг үнэлж дүгнэж сурагчдад танилцуулахад хүндрэлтэй
- Цаг хугацаа их шаардана.
- Суралцагч даалгаварыг явуулахад хүндрэлтэй /багш суралцагчдын илгээсэн даалгаварыг харахгүй байх үлдээх магадлал өндөр / гэх мэт маш олон сул талыг нэрлэж болохоор байна.

2

ТА ЦАХИМ ХИЧЭЭЛИЙГ ХЭРХЭН СУРАГЧДАД ТҮГЭЭЖ ДҮГНЭЖ БАЙНА БЭ?

75% Facebook групп ашиглан төрөл бүрийн хичээлийг түгээж байна.



15% Zoom ашиглан хичээл сургалтыг явуулж байна.

6% Facebook live ашиглан хичээл сургалтыг явуулж байна.

4% Бусад source ашиглаж байна.

СУРГУУЛИЙН БҮХИЙ Л ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭГ СИСТЕМД ОРУУЛАХ

СТАТИСТИК ДҮН МЭДЭЭГ ХЯЛБАР БАЙДЛААР НЭГТГЭН ГАРГАХ



ЦАХИМ ЖУРНАЛ ХӨТЛӨХ


ЭЦЭГ ЭХИЙН ХАРИЛЦАА ХОЛБООГ ОЙРТУУЛАХ

3

СУРАЛЦАГЧДЫН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

- Цахим хичээлийг дэс дараалан ойлгомжтой байдлаар зохион байгуулах
- Багш суралцагч тус бүр зөвлөгөө тайлбарыг илгээх
- Суралцагч тус бүр үнэлгээг илгээх
- Гэрийн даалгавар илгээх хэсэгтэй байх
- Facebook-ээр дамжуулан цахим хичээлийг түгээхэд зарим хичээлийг олдоггүй учир хичээл бүрээр зохион байгуулах
- Шууд видео хэлбэрээр цахим хичээл зохион байгуулах
- Шалгалтын дүнг шууд өөрөө харах боломжтой байх
- Мэдээ мэдээллийг цаг тухай бүрд авах боломжтой
- Сургуулийн талаарх мэдээ мэдээллийг хурдан авах боломжтой

СИСТЕМИЙН ТУХАЙ: Багш эцэг эх сурагчдыг сургуультай нь холбож түргэн шуурхай мэдээлэл солилцох үндсэн зорилготой. Сургуулийн дотоод үйл ажиллагааг хамарсан удирдлагын мэдээллийн системийг бий болгож сургууль, эцэг эх, сурагчдын хоорондын харилцааг бий болгож сургалтын үйл ажиллагааг автоматжуулах, дүнгийн мэдээлэл, тайлан мэдээ, хичээлийн хуваарь, зан байдлын мэдээлэл гэх зэрэг мэдээллийг нэг дор интернет ашиглан хаанаас авах боломжтой мэдээллийн нэгдсэн систем юм.



ЦАХИМ СУРГУУЛИЙН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭХ БӨЛСӨН ҮНДЭСЛЭЛ:


Дэлхий даяар тархаад буй Covid 19 тахалтай холбоотойгоор сургалтын үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлсэн. Мөн боловсролын байгууллагын хүрээнд суралцагч, эцэг эх, сургуулийн захиргаанд түгээмэл тулгардаг дараах асуудлууд байдаг. Тэдгээрийг ангилан дурдвал:

БАГШ НАРТ ТУЛГАРДАГ ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД:

- Бүх суралцагчдын талаар өдөр бүр эцэг эхтэй нь харилцаад мэдээлэх боломж муу (Утсаар эцэг эхчүүдэд мэдээ мэдээлэл, давтлага зөвлөмж байнга өгөхөд зардал ихтэй)
- Суралцагчдын талаарх мэдээллийг боловсруулахад хугацаа их шаарддаг (Дүн, харилцах дэвтэр гэх мэт.)
- Суралцагчийн болон ар гэрийн талаарх судалгаа муу
- Суралцагчидтай зөвхөн нүүр тулж ажилладагаас давтлага өгөх, нэмэлт хичээл ороход цаг хугацаа хүрэлцдэггүй
- Эцэг эх болон удирдлагад өөрийн хичээлийн агуулгыг танилцуулах боломж бололцоо бага
- Цахим хичээл, хичээлийн хэрэглэгдэхүүн архивлах хадгалах боломжгүй
- Бусад багш ажилчидтай мэдлэг, туршлага солилцох боломж бага
- Эцэг эхэд мэдээ мэдээлэл зарыг хурдан шуурхай хүртээмжтэй түгээхэд цаг хугацаа их зарцуулдаг
- Цахим хичээлийг түгээж дүгнэх цахим сургалтын орчин хүндрэлтэй

СУРАЛЦАГЧДАД ТУЛГАРДАГ ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД:

- Өөрийнхөө дүн мэдээллийг байнга харах, хянах боломжгүй
- Хичээлийн хуваарь, гэрийн даалгавар болон багш заасан боловч ойлгоогүй
- Удирдлага, багш нартайгаа чөлөөтэй харилцаж санал бодлоо илэрхийлэхэд хэцүү байдаг




СУРАЛЦАГЧДАД ТУЛГАРДАГ ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД

- Өөрийнхөө дүн мэдээллийг байнга харах, хянах боломжгүй (Анги болон сургуульдаа хэддүгээрт жагсаж байгаа гэх мэт)
- Хичээлийн хуваарь, гэрийн даалгавар болон багш заасан боловч ойлгоогүй хичээл зэргээ интернетээс авах боломжгүй
- Удирдлага, багш нартайгаа чөлөөтэй харилцаж санал бодлоо илэрхийлэхэд хэцүү байдаг Сургуулиас зарласан мэдээ мэдээллийг цаг алдалгүй авах боломж тааруу гэх мэт

СУРГУУЛИЙН УДИРДЛАГАД ТУЛГАРДАГ ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД


- Статистик, тайлан мэдээ нэгтгэхэд олон баримт бичгээс хайхад хүндрэлтэй
- Сургууль болон багш нар эцэг эхчүүдтэй харилцах болон санал хүсэлтийг авахад хүндрэлтэй
- Эцэг эх болон багш нартай мэдээлэл солилцоход цаг хугацаа хөрөнгө мөнгө их зарцуулдаг
- Эцэг эхчүүдээс сургуулийн үйл ажиллагаа, багш нарын талаарх санал хүсэлтийг өгөх боломж бололцоо тааруу
- Цахим хичээлээр сургалтын үйл ажиллагааг явуулж байгаа үед багш нарын цахим хичээл болон суралцагчдын хамрагдаж буй байдлыг хянаж дүгнэхэд асуудалтай гэх мэт

ЦАХИМ
СУРГУУЛЬ



ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

**ЗАХИДАЛ СИСТЕМД
БАЙГАА БҮХ ХЭРЭГЛЭГЧИД
ХООРОНДОО ХАРИЛЦАХ
МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ
ФАЙЛ ХУВААЛЦАХ
БОЛОМЖТОЙ**




- Админ болон номын санч .pdf болон .docx төрлийн файл оруулах ба суралцагч нарт нээлттэй модуль юм. Суралцагч ямар ном хэрэгтэй байгаагаа шаардах номны хүсэлт гаргах хэсэгтэй болно

- Анги бүлгийн сонголт өнөөдрийн огноотой оруулсанаар тухайн ангийн суралцагчдын ицрийг 3 янзаар бүртгэх боломжтой танхимын хичээл орж буй явцадилүү тохиромжтой.

- Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа ирээдүй цагт хийгдэх ажлийг төлөвлөж төлөвлөсөн ажлыг багш ажилчид харах багш ажилчид суралцагч нар харах боломжтой


ИРЦИЙН МЭДЭЭЛЭЛ, ДҮНГИЙН НЭГТГЭЛ ЦАХИМ ХИЧЭЭЛ

Анги бүлэг суралцагчийн сонголтыг хийснээр тухайн хүүхдийн хичээлийн нэгдсэн дүн багшийн үнэлгээ сэтгэгдэл харагдах болно. Энэхүү статистик мэдээлэл эцэх эхийн бүртгэлээр орох үед мөн адил харагдана.




Анги бүлэг хичээлийн сонголт хийснээр тухай ангийн хүүхдүүд тус хичээлд ямар үнэлгээтэй суралцсан болон жилийн эцсийн дүн шууд бодогдож гарах юм.

Олны санал болон гарын үсэг цуглуулах ажил цахимаар авах боломжтой багш, суралцагч, эцэг эхчүүд гэх мэт ангилж санал авах хэсэг юм. Үүсгэсэн санал асуулга системийн нүүр хуудсанд шууд харагдах юм



Хэрэглэгч бүр өөрийн файл хадгалах хэсэгтэй бөгөөд Google Drive тай ижил зохион байгуулалттай бүх төрлийн файл хуулах татаж авах хавтаслах боломжтой Storage юм.





ДҮГНЭЛТ

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь салбартаа анхлан өөрийн бүтээж хөгжүүлсэн цахим сургалтын системийг нэвтрүүлж ашиглалтанд орууллаа. Миний бие өөрийн зохиосон цахим сургалтын системийг сургуулийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр дараах давууталуудыг олж авсан гэж үзэж байна. Үүнд:

- Цахим хичээлийн чанар, сургалтын үр дүн, суралцагчдын оролцоог сургалтын албанаас хянаж үнэлж зөвлөмж өгч байгаа тул сургалтын чанартаахиц гарч байна.
- Эцэг эх, суралцагчдын хичээл сургалтыг тогмтол хянаж багш, сургууль, эцэг эхийн холбоо сайжирснаар суралцагчдыг идэвхи нэмэгдэж байна.
- Багш цахим хичээлийг оруулж тухайн хичээлд тохирсон гэрийн даалгаврыг илгээж суралцагч тус бүрт зөвлөмж, үнэлгээг явуулснаар үнэлгээний нууцлалтай байдал хангагдаж байна.
- Суралцагч гэрийн даалгаврыг явуулахад хялбар болсон.
- Багш суралцагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадвар дээшилсэн.
- Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн.
- Статистик дүн мэдээг хялбар байдлаар гаргах боломжтой/цаг хугацаа хэмнэж байна./
- Суралцагчид сургуулийн захиргаанд санал хүсэлт гаргах боломжтой
- Шууд хэлбэрээр цахим хичээл зохион байгуулах боломж бүрдсэн.
- Шалгалтыг хугацаа тохируулан авах боломж бүрдэж байна.
- Шалгалтын дүнг суралцагч шууд мэдэх боломжтой учир үнэлгээнд ямар нэгэн эргэлзээ төрөхгүй итгэлтэй байна.
- Суралцагчдын идэвхи сайжирсан
- Багш нарын цахим хичээл бэлтгэх ур чадвар дээшилж байна.
- Цахим хичээлийн нэгдсэн сан бүрдэж байна.

Мөн тусгайлан тус сургуулийн захиргаа үүрэн телефоны байгууллагуудтай гэрээ хийн гар утаснаас тухайн цахим систем рүү суралцагч үнэгүй нэвтрэх эрхийг олгосноор суралцагч интернетгүй болон ямар нэгэн data байхгүй үед ажиллах бүрэн боломжийг бүрдүүлж өгсөн нь хамгийн том давуутал болж байна гэж дүгнэж байна.



ТАНИЛЦУУЛГА

ОВОГ: Сэргэлэн
НЭР: Энхсаруул

ТӨГССӨН СУРГУУЛЬ: ҮҮТДСургуулийг
Чимэглэх зураач
МУБИС-ын Урлаг судлалын магистр

АЖЛЫН ТУРШЛАГА: 2001-2002 онд Мон-
Тулга ХХК-д Ерөнхий зураач
2004 оноос ҮҮПК-ийн “Бэлэг дурсгалын зүйл
урлаач” мэргэжлийн багш
Мэргэжлийн зэрэг: “Тэргүүлэх багш”

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

- | | |
|-------------------------------|------------|
| - Оны шилдэг бүтээл | - 2003 он |
| - Алтан од | - 2005 он |
| - Шилдэг хөтөлбөр | III-р байр |
| - Шилдэг уран бүтээлч | - 2009 он |
| - Талархал | - 2014 он |
| - Занабазарын нэрэмжит шагнал | - 2016 он |
| - Оны шилдэг багш | - 2018 он |
| - Боловсролын яамны жуух | - 2018 он |
| - Хөдөлмөрийн яамны жуух | - 2018 он |
| - Оны шилдэг багш | - 2019 он |

Үйлдвэрлэл,
сургалтаар
суралцагчийн бүтээлч


үйлийг хөгжүүлэх, сургалтын арга
зүйд өөрийн өнгө, төрхийг илтгэх брэнд,
патентчилагдсан бүтээлийг суралцагчдад
таниулж, тэднээр зөвхөн тухайн сургуульд сурч
байгаа суралцагч л хийж болох Хүүхэлдэйн загваруудыг
ашиглан хийж байгаа инноваци, судалгааны ажлыг хийж
хэрэгжүүлж байгаа багш Д.Энхсаруулын судалгааг танилцуулья.

Монголын хүүхэлдэйн урлагт шинэ санаа, шинэ
технологийн арга ажиллагааг нэвтрүүлэх боломжийг
эрэлхийлсэн санааг хадгалсан бүтээлийг хийсэн.

Багшийн бүтээлийн онцлог нь хүүхэлдэйн чимэглэх
урлагийн түвшинд шинэлэг санаа, шинэ технологи арга
ажиллагааг нэвтрүүлэн урьд хийж байсан бүтээлүүдээс
илүү өвөрмөц болжээ. Зохиомжийн шийдэл нь өөрийн гэсэн
өвөрмөц өнгө аястай, хэлбэр хийц, хөдөлгөөн донж, төрх нь
бүгд үндэсний хэв маягийг орчин үеийн хэлбэрт оруулан
зохиомжилж чадсан байгаа нь харагдаж байна. Монголчууд
эртнээс алт, мөнгө, чимэг зүүлтийг өргөн хэрэглэж ирсэн
бөгөөд дахин давтагдашгүй хэлбэр хийцийг агуулсан үнэт чулуу,
сийлбэр, уран дархан, баримлын аргыг хослуулан бүтээснээр
Монгол хүүхэлдэйн төрөлд шинэ алхам болж чадсан байна.



ОЛОН ТАЛААРАА ИННОВАЦИ БОЛЖ БУЙ УГ ХҮҮХЭЛДЭЙНҮҮД НЬ /БААТАР БОЛОН ХӨӨРӨГТЭЙ ХҮҮ, 12 ЖИЛТЭЙ ХҮҮХЭЛДЭЙ, ДАРЬГАНГА ХОС, ХАЛХ ЭХНЭР/ ДАДЛАГЫН ХИЧЭЭЛЭЭС БЭЛЭН БОЛЖ ГАРСНААР ЗОЧИДОД БЭЛЭГ БОЛОН ТҮГЭЭГДЭЖ БУСАД ХҮМҮҮСТ ХҮРЧ ЭРГЭЭД УГ ХҮҮХЭЛДЭЙГ ЗАХИАЛАХ ЗАХИАЛАГЧИД БИЙ БОЛЖ БАЙГАА.



ХҮҮХЭЛДЭЙНҮҮДИЙН ШИНЭЛЭГ ТАЛ:

- Бүтээлцүдийн хэлбэр хийц давтагдаагүй
- Бүтээлцүдийн өнгийн шийдэл нь завсарын болон хурц тод өнгө давамгайлсан
- Бүтээлцүдийг хийхдээ сийлбэр болон уран дархан, цнэт чулууны технологи арга ажиллагааг хослуулсан.
- Үндэстэн ястаны хувцас чимэглэлийг орчин үеийн хэлбэрт оруулан өөрчилсөн зэрэг болно.

МОНГОЛЫН ХҮҮХЭЛДЭЙН УРЛАГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮД:



МОНГОЛ ДАРХАН МЭРГЭЖЛИЙН ЧИМЭГЛЭЛИЙН ЗҮЙЛ ХИЙХ ХИЧЭЭЛИЙГ ЦАХИМААР ЯВУУЛСАН ТУРШЛАГА



**ОВОГ: ТОГТОХСҮРЭН
НЭР: ОТГОНБААТАР**

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

СУИС-ЫН ХАРЬЯА ДҮРСЛЭХУРЛАГИЙН
ДЭЭД СУРГУУЛИЙН МОНГОЛ ДАРХАН
АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1999-2004 Зоос гоёл ХХК-д Загварчин
- 2004-2008 Алтан соронзон ХХК-д Дархан
- 2008- ҮҮПК-д багш

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: Заах аргач

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:


- 2015 онд ХНХЯ-ны Жуух бичиг
- 2018 онд ХНХЯ-ны “Тэргүүний ажилтан”

Монгол дарханы багш Т.Отгонбаатар нь “Модон дээр мөнгө, зэс, зөөлөн төмөр утсаар шигтгэж /ЖИЙЖҮҮДЭХ/ хээлэх арга ажиллагаа”-г сэдэвт чадамжийн нэгжийг цахимаар зурган хэлбэрийг даган дууриах, бичлэг хийж даган дууриалгах аргуудыг сонгон заасан бөгөөд дараах үр дүн гарсан гэж үзжээ.

ДАРХАН ХҮН БУРХАН УХААНТАЙ.

Алсын зайнаас сургалт явуулах нь цар тахлын үед дэлхий нийтийн боловсролын байгууллагын томоохон асуудал болж манай улсын сургалтын системд шинэ техник технологи сургах суралцах арга барилыг анхаарах хэрэгтэй болж байгааг харуулж байна.

Монгол дархны урлалд халуун ба хүйтэн жийжүүдэх гэсэн арга ажиллагаа байдаг. Уламжлалт энэ аргаар одоог хүртэл төмөр ба өнгөт төмөр дээр дархчууд урлалаа хийсээр байгаа. Жийжүүдэх нь тайлбар толинд төмрийг мөнгө гуулиар чимэглэх, мөнгө гууль суулгахыг хэмээжээ. Тэгэхээр уг арга ажиллагаа нь маш нарийн мөн ур чадвар, анхаарал шаарддаг байна. Ковид-19 цар тахлын үед бүх төрлийн сургалтын байгууллага үйл ажиллагаагаа цахим хэлбэрт шилжүүлж буй энэ үед мэргэжлийн дадлага хичээлүүд өөрсдийн боломжоор цахимаар суралцагчдад мэдлэг, чадвар, хандлагыг олгож байна.



Мэргэжлийн боловсролын салбар сургуулиудын гол тулгуур зүйл нь дадлагын хичээл байдаг билээ. Дадлагын хичээл оновчтой явагдснаар тухайн сургуулиас бэлтгэгдэн гарч буй мэргэжилтнүүд ажиллаж буй салбартаа өөрийн хувь нэмрээ бүрэн оруулж мэргэжлийн боловсролын салбарын нэр хүнд цаашлаад улс орны хөгжил дэвшил яригдах юм. Дадлагын хичээлийг сайжруулахын тулд мэргэжлийн багш нар онлайн болон вебэд суурилсан сургалт зохион байгуулж эхэлж байна.

Мэргэжлийн боловсролын салбар сургуулиудын гол тулгуур зүйл нь дадлагын хичээл байдаг билээ. Дадлагын хичээл оновчтой явагдснаар тухайн сургуулиас бэлтгэгдэн гарч буй мэргэжилтнүүд ажиллаж буй салбартаа өөрийн хувь нэмрээ бүрэн оруулж мэргэжлийн боловсролын салбарын нэр хүнд цаашлаад улс орны хөгжил дэвшил яригдах юм. Дадлагын хичээлийг сайжруулахын тулд мэргэжлийн багш нар онлайн болон вебэд суурилсан сургалт зохион байгуулж эхэлж байна.

Танхимын сургалтын давуу тал: Анхаарал сайжирсан, биеэ даах нь идэвхжсэн, харж ойлгох сонсох идэвхжсэн, асуулт тавих нь ихэссэн.

Сөрөг тал: Цахим хэрэгсэл дутмаг, багаж буруу сонгосон, сургалтын материал дутуу, алдаа их гаргасан.

Цахим сургалтын давуу тал: Анхаарал сайжирсан, биеэ дааж асуудалд хандах байдал ихэссэн, оновчтой асуулт асуух нь ихэссэн.

Сөрөг тал: Шууд асууж болохгүй, нэгэн зэрэг бүгдийг харах боломжгүй, бүх суралцагчтай холбогдох боломжгүй гэх дүгнэлтүүд гарсан. Дүгнэлтээс харахад мэргэжлийн хичээл цахимаар ороход мэргэжлийн ур

чадвар нэмэгдэхээс гадна давхар хувийн чадварууд шаардах ба цахим хичээлээр бие даах чадвар нэмэгдэж буйг тодотгож хэлэх хэрэгтэй.

Багшийн сургалтын үр дүнгээс гадна бүтээлийг онцлож байгаа явдал нь “Монгол дарханы урлагт


Жийжүүдэх арга технологи нь зөвхөн метал дээр хийдэг бол багш Модон дээр жийжүүдэх аргыг хэрэглэж, уламжлалт хээ угалзыг суурилуулж байгаа” -гаараа мөн инновацийг нэвтрүүлэх, судалгаат ажлаа хийж байгаа юм.

МОНГОЛ
ДАРХАН



TINKERCAD ЦАХИМ СИМУЛЯЦЫН ПРОГРАММ АШИГЛАН ЭЛЕКТРОНИКИЙН ДАДЛАГА ХИЧЭЭЛ ЗААХ НЬ

Мэдээллийн технологитой холбогддог цахим хэрэгслийн засварчин болон цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан мэргэжлүүдийн электроникийн дадлагын хичээлд Tinkercad цахим симуляци ашигласан мехатроникийн багш Н.Ганболд багшийн туршлагатай танилцъя.



ОВОГ: НИНЖЭЭ
НЭР: ГАНБОЛД

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

- 2011 онд МУБИС-ийн ФТС-ийг Физик-электроникийн багш
- 2015 онд МУБИС-ийн ФТС-ийг Боловсрол судлалын магистр

АЖЛЫН ТУРШЛАГА:



- 2011 оноос ҮҮПК —д “Электроникийн багш”

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: Заах аргач

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

- “Автомат робот” 2017 оноос жил бүр амжилттай зохион байгуулсан
- “Автомат робот 2019” Их дээд сургууль болон МСҮТ-үүдийн дунд зохиогдсон тэмцээний “Шилдэг удирдагч багш” —аар шалгарсан
- “Хөдөлмөрийн алдар” 2015
- БСШУЯ-ны Жуух бичиг 2019
- 2019 онд ҮҮПК Шилдэг зохион бүтээгч багш
- ABU ROBOCON 2019 олон улсын тэмцээний шүүгчээр ажилласан.

TINKERCAD цахим симуляцийн тухай: Программыг tinkercad.com сайтын circuit хэсэг руу нэвтэрч электроникийн төрөл бүрийн схем холбож программ бичиж түүнийгээ бүр симуляци хийж ажиллуулж үзэх боломжтой бүгдэд нээлттэй программ юм.




TINKERCAD СИМУЛЯТОРЫН ОНЦЛОГ ШИНЖ ЧАНАРУУД:

- Интернет орчинд өөрийн бүртгэл дээр цахим сан үүсгэх боломжтой.
- Мэргэжлийн программ хангамжууд ихэвчлэн лиценз шаарддаг бол tinkercad нь үнэ төлбөргүй ба зөвхөн интернет орчин л байхад хангалттай.
- Программын инстал суулгах шаардлагагүй.

Энэ симуляци нь мэдээллийн технологийн анхан шатны суурь мэдлэг шаардах бөгөөд суралцагчдад анхан шатны зөв суурь бий болгосноор цаашид мэргэжлийн хичээлийн үйлдвэрлэлийн дадлагаас өмнө аль нэг хичээлийг бие даан судлах цагийг баталгаажуулан сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх нь үр дүнтэй ихтэй гэсэн дүгнэлтэндээс харагдаж байна. Мөн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж дээр сайн ажилладаг болох хэрэгтэй ч түүнийг орлох симуляци програмууд дээр ажиллаж сурах нь ажлын байрны нэгэн давуутал болсоор байна. Энэ жишээ бол зөвхөн техник технологийн мэргэжлүүд дээр яригдаж байгаа ч бусад төрлийн мэргэжлийн дадлагын хичээл дээр мөн адил программыг турших боломжтой юм.

Сонгосон ангиудын суралцагчдаас 3 удаагийн судалгаа авсан бөгөөд 1. Компьютер техник хэрэгслийг ашиглан сургалтаа авах боломжтой эсэх, 2. Үндсэн хичээлийн агуулгыг ойлгосон эсэх 3. Агуулгын хүрээнд дадлага хийгээд гарсан үр дүн гэсэн 3 асуулга судалгааг авч swot шинжилгээ хийлээ.





МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШИЙГ ВЭБЭД СУУРИЛСАН СУРГАЛТААР ХӨГЖҮҮЛЭХ НЬ (ЕЭТ-ИЙН БАГШ НАРЫН ЖИШЭЭН ДЭЭР)

ОВОГ: НАРАНХҮҮ

НЭР: АЛТАНСУВД

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

-МУИС-Монгол хэл Соёлын Сургуулийг Монгол-Солонгос хэл судлал

-2015 онд Батлан Хамгаалахын Их Сургууль-Цэргийн Командын сургуулийг Менежмент, төрийн захиргааны мэргэжлээр

-2016 онд Монгол хэл шинжлэлийн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан

-2017-оноос өнөөг хүртэл БНХАУ-ын Төв Хятадын Багшийн Их сургуульд “Боловсролын Технологийн ухаан”-ы докторантураар суралцаж байна

АЖЛЫН ТУРШЛАГА:

-2013 онд “World Kore Group” орчуулагч багш

-2014-2016 онд БТК-д МХУЗ-ын багш

-2016 онд “Гэрэлт-Ирдээдүй олон улсын сургууль МХУЗ-ын багш

-2016 оны 9 сараас одоог хүртэл Гандийн нэрэмжит YUPK

ЦАХИМ ХАЯГ: Altansuvd2121@gmail.com

Орчин үеийн багш гэх ойлголтод багш нь тасралтгүй хөгжигч мөн эрэл хайгуулч байх шаардлага багтана. Мэдээллийн технологийн үсрэнгүй хурдацтай өнөө үед багш бүр цахим сургалтаар хөгжих, мэргэжлээ дээшлүүлэх боломж нээлттэй болсоор байгаа билээ. Цахим сургалт гэдэг нь нэг үгээр хэлбэл МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ-д суурилсан сургалт юм.



Цахим сургалтын материалыг боловсруулах нь танхимын сургалтын материал боловсруулахаас үнэтэй, цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр их шаарддаг. Харин боловсруулсны дараа цахим сургалтыг явуулах нь танхимын сургалт явуулахаас олон давуу байдаг. МХУЗ-ын багш Н.Алтансүвдэн судалгаа нь МБС-ын салбарын багш нарын жишээн дээр тулгуурласан онцлог юм.

Боловсролын салбарт их, дээд болон ЕБС-ийн багш нарын сургалтан дээр түлхүү анхаарч, МБС-ын ерөнхий эрдмийн багш нарыг тусдаа хэсэг хэмээн авч үзэж буй нь анхаарал хандуулах асуудал юм. Тиймээс МБС-ын байгууллагын ерөнхий эрдмийн болон мэргэжлийн багш нар заах арга зүй, сургалтын үйл ажиллагааны талаар салбарын бусад байгууллагын ижил мэргэжлийн багш нартай туршлага солилцох, мэдээлэл дамжуулах хэрэгцээ бий болдог.

Үүнээс үүдэн багш нар вебэд суурилсан сургалтаар хөгжин, вебээр дамжуулан холбогдон харилцах нь цаг хугацаа хэмнэсэн, хараат бусаар бие дааж өөрийгөө дайчлан хөгжихөд ашиг тустай. Багшийн хөгжилд нөлөөлж болох арга замуудыг эрэлхийлснээр аль нэг платформ ашигласнаас илүү МБС-ын багш нарын нэгдсэн систем бий болгох нь үр дүнтэй байна. Үүний үндсэн дээр ИТЕСН вебсайтыг үүсгэн хөгжүүлж бүрэн үйл ажиллагаагаа эхлэхэд 60%-тай явж байна.

АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

1. Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд цахим сургалт, хөгжлийн ИТЕСН вэбийг ашигласнаар хот хөдөө гэлтгүй мэргэжил, ажилласан жил, туршлага, боловсролын болон мэргэжлийн зэрэг зэргийг үл харгалзан МБС-тажиладаг, өөрийгөө хөгжүүлэх боломж нөхцөл эрэлхийлдэг хэн бүхэнд хүрэх боломж бүрдэх юм.
2. Өнгөрсөн 11 сард ҮҮПК-ийн 5 багшийн гадаад хэлний мэдлэгийг сайжруулах зорилго бүхий ажлыг 1 сарын хугацаатай аяны хэлбэрээр өрнүүллээ. Манай багш нарын дунд сурах, хөгжих хүсэл тэмүүлэл их ч дээрх нөхцөл, боложийн бүрдүүлэлт нь бага байдгийг өнгөрсөн хугацаанд “Лингорс” олон улсын компанитай хамтран ажиллаж багш нарын англи хэлний мэдлэг чадварыг ахиулах зорилго бүхий “Extensive reading in Mongolia” үндэсний хэмээний уншлагын марафоны үйл явцаас ажиглагдаж байв.
3. Мөн ҮҮПК-ийн Монгол-Англи хэлний секцийн багш нарт цахим хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх, цахим орчинд шалтгалтын материал боловсруулах, асуулга бэлтгэх, цахим хичээл бэлтгэхэд өргөн хэрэглэгддэг программ зэрэг сургалтын чанартай мэдээлэл олгох явцад ч мөн ажиглагдаж байв.
4. Дорнод, Дархан, Төв аймаг, Баянчандмань, УБ хотод байрлах хэд хэдэн МСҮТ, Политехник коллежийн монгол хэлний багш нартай хамтран МБС-ын сургалтын байгууллагад ашиглагдах сурах бичиг боловсруулах ажлыг эхлүүлэхээр ажиллаж, тэдгээр багш нартай сургалтын орчин, зохион байгуулах арга барилын тухай харилцан санал солилцох, туршлага судлах зэрэг ажлын цахим орчинд Google classroom, Фэйсбүүк груп ашиглан мөн сарын хугацаанд өрнүүллээ.
5. Энэ онд ХНХЯ-ны МБС-ын сургалт хариуцсан хэлтэс ЕЭТ-ийн багш нарыг хөгжүүлэх бас нэгэн ажлыг эхлүүлж байгаа нь цахим даалгаврын сан үүсгэх явдал юм. Харин шинэ оны босгон дээр МБС-ын ЕЭТ-ийн багш нарыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа билээ.

“ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН БАГШИЙН ҮНДСЭН УР ЧАДВАРЫН (ХАНДЛАГА) ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГАА”



**ОВОГ: ЧИМЭДРЭГЗЭН
НЭР: МӨНХСАЙХАН
ТӨГССӨН СУРГУУЛЬ:**

- 1984-1988 онд ОХУ-ын Иваново хотын

Эрчим Хүчний Коллеж

- 1995-1999 онд ШУТИС Эрчим Хүчний

Инженерийн Сургууль Цахилгааны инженер, /Бакалавр/

- 2017-2020 онд ХААИС-ийн Магистр Докторын Сургууль
/Магистр/

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1988-1995 онд Эрчим хүчний барилга угсралтын трест /Цахилгааны монтер, техникч/

- 1995-2008 онд Эрчим хүчний барилга угсралтын трест /Цахилгааны зураг төсвийн инженер/

- 2009-2010 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургууль Цахилгааны багш

- 2010 оноос ҮҮПК-д Цахилгааны багш

**МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: “Заах аргач”
ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:**

- 1996 онд - “Эрчим хүчний ойн медаль”

- 2013 онд Хөдөлмөрийн Яамны жуух

- 2016 онд Эрчим Хүчний Яамны тэргүүний
ажилтан

- 2020 онд Хөдөлмөрийн Яамны тэргүүний
ажилтан

ЦАХИМ ХАЯГ: Munkh_chimed@yahoo.com

Одоогийн энэ зуунд хандлага хүнийг чимдэг болсон. Чадварлаг мэргэжилтнийг дүгнэх гол чадварын зайлшгүй нэг шалгуур нь мэдээж мэргэжлийн ур чадвар ч гэлээ, ажил олгогчдоос хүсч байгаа дараачийн чухал шалгуурт хандлага, төлөвшил багтаж байна. Мэргэжлийн боловсролын салбар байгууллагууд сайн мэргэжилтэн бэлтгэхийг гол зорилгоо болгож байсан ч сүүлийн үед зөв хандлага төлөвшилтэй чадварлаг мэргэжилтэн бэлтгэхийг хэтийн зорилгоо болгон ажиллаж байгаа билээ. Цахилгааны багш С.Мөнхсайханы Техникийн боловсролд судалсан туршлагыг хүргэе.



Хөдөлмөр эрхлэх үндсэн ур чадварыг 3 хэсэгт хуваан авч үзэв. Үүнд: зохион байгуулалтын, судалгаа эрэл хайлтын болон харилцааны ур чадвар. Харилцааны ур чадвар буюу EQ (emotional quotient)-г мэргэжлийн хичээл дээр мэргэжлийн багш нар суралцагчдад төлөвшүүлэх олон асуудал тулгардаг. Судалгаагаар мэргэжлийн багш бэлтгэх сургалтын агуулга, хөтөлбөрт суралцагчдад хэрхэн үндсэн ур чадвар эзэмшүүлэх талаар дурьдаагүй, суралцагчдын үнэлгээний системд үндсэн ур чадварыг үнэлэх аргачлал байдаггүй, мэргэжлийн сургалтаар үндсэн ур чадварыг эзэмшүүлэх арга замыг заадаггүй гэсэн үр дүнгүүд гарсан бөгөөд эдгээр нь үндсэн ур чадварын ойлголт тодорхой бус бөгөөд нэгдсэн ойлголтгүй, үүний талаархи ном гарын авлага дутмаг байдаг нь гол бэрхшээл болж байна. Багш өөрөө хэдий чинээ сайн хөгжинө суралцагчдаа төдий чинээ хөгжиж чадна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын багш нар нь ажлын байрандаа үндсэн ур чадвараа хөгжүүлэх нөхцөл боломжоор хангагдсан гэж үзэж байгаа ч үндсэн ур чадварын талаарх ойлголтын зөрүү ихтэй, түүнийг эзэмшүүлэх үнэлж дүгнэх аргачлал байхгүй байна. Мэргэжлийн боловсролын эрх зүйн баримт бичгүүдэд үндсэн ур чадварыг хөгжүүлэх талаар бодлогын чанартай тодорхой заалт оруулаагүй байна. Дадлагын хичээл дээр үндсэн ур чадвар ялангуяа EQ ойлголтыг төлөвшүүлэх цаг гардаггүй нь бас нэгэн бэрхшээл билээ. Тийм учраас мэргэжлийн хичээл дээр практик туршлага хуримтлуулж ерөнхий эрдмийн хичээл дээр онолын мэдлэгээ үзэн хандлага төлөвшлийн талаар ойлголттой болж байгаа нь одоогийн шийдэл юм.





МСҮТ-Д СУРАЛЦАЖ БАЙГАА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧДАД ТЭГШ СУРАЛЦАХ НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ НЭГЭН ЖИШЭЭ

ОВОГ: ДАВАА

НЭР: СОЛОНГО

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

-2002 - 2006 онд МУБИС - БУС

АЖЛЫН ТУРШЛАГА:

-2006 онд МУБИС-БУС Лаборант

-2006-2007 онд Jica Зоопланктон судлаач

-2007 оноос УУПК –д Химийн багшаар

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: “Тэргүүлэх”

ЦАХИМ ХАЯГ: anukesuik99@gmail.com

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

- 2011 онд Бүсийн Шилдэг заах аргач багш

-2011 онд Улсын Шилдэг заах аргач багш

- 2015 онд УУПК Шилдэг заах аргач багш

-2018 онд Шилдэг заах аргач багш

-2018 онд Бүсийн Шилдэг заах аргач багш

II байр


-2018 онд Улсын Химийн Олимпиадын

Тэргүүн байр

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрэлт хэрэгцээг хангахуйц боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах хөтөлбөр”-ийг Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар баталж 2003-2008 онд хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн. Мөн нийгмийн болон хувь хүний сэтгэл зүй, хандлагад өөрчлөлт гаргах, ердийн сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах тэгш боломжоор хангасан орчныг бүрдүүлэх эхлэлийг тавьж, улмаар үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд тодорхой ахиц гарсан. МБС-т хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцан мэргэжилтэй болсоор байгаа ч тэдэнд зориулсан сургалтыг бий болгох саналыг тусгасан туршлагыг авч үзье.

Химийн багш Д.Солонго Мэргэжлийн боловсролын салбарт суралцаж байгаа суралцахад бэрхшээлтэй суралцагчдад тэгш суралцах боломжинд дэмжлэг үзүүлэх санааг өөрийн сургуулийн суралцагчдад Портеж хөтөлбөрийн жишгээр судалгаа, төлөвлөгөө, туслах дэвтэр, цахим хэрэглэгдэхүүн болон сургалтын арга боловсруулах нэгэн жишээ болгон хийжээ. Портеж хөтөлбөр нь 1972 онд АНУ-ын Вискинсон мужийн Портеж хотод боловсруулсан. Хотын ихэнх хүн ам нь төвөөс алслагдмал, тархмал суурьшилтай байснаас дэмжлэг шаардлагатай тухайн хүүхдийн гэртнь очиж зөвлөгөө өгч эхэлжээ. Өнөөдөр дэлхийн 35 гаруй орон уг хөтөлбөрийг өөрсдийн хэлэнд хөрвүүлэн ашиглаж байна.



-Хөгжлийн үнэлгээ
-Даалгавар сонгох
-Даалгаврыг гүйцэтгүүлэх төлөвлөгөө боловсруулах
-Гэрт даалгавар ажиллуулах
-Үр дүнг шалгах гэсэн тасралтгүй үе шатаар явагддаг онцлогтой.


Тэгш хамруулан сургах сургууль нь хүүхдийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж сурах орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай боловч уг шаардлагад нийцсэн МБС-ын сургалтын байгууллага байхгүй байна. 2019-2020 оны хичээлийн жилд ҮҮПК-д 29, 2020-2021 оны хичээлийн жилд 14 хөгжлийн бэрхшээлтэй элсэгч тус тус элсчээ.

ДҮГНЭЛТ

Тусгай хэрэгцээт суралцагчид МСҮТ болон Политехник коллежид элсэх хэрэгцээ, хандлага их байна.

-Элсэж байгаа тусгай хэрэгцээт суралцагчдад мэргэжлээс хамаарсан шаардлагыг тодорхойлох хэрэгтэй байна.

-Элсэлтийн явцад тусгай хэрэгцээт суралцагчдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх дохионы хэлтэй, тусгай шаардлага хангасан багш ажиллах шаардлагатай байна.



-Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сурахад дэмжлэг үзүүлэх багш нар тэдэнд туслах сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага болон хөгжлийн график хөтлөх анализ хийх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл мэргэжил эзэмшихээр зорин ирсэн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг аргацаах, харилцахад бэрхшээлтэй хэмээн өдөр өнжүүлэх байдлаар сургалтыг зохион байгуулмааргүй байна.

-Тусгай хэрэгцээт суралцагчдад сургалт зохион байгуулахад сургуулийн удирдлагаас эхлэн баг ажуулах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах, багш нараа хөрвүүлэх, дохиожуулах шаардлагатай байна.

-МБС-ын сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сургаж мэргэжилтэн болгож төгсгөснөөр тухайн суралцагч өөрийгөө нийгмээс тусгаарлахгүй бусадтай ижил гэдгээ ухамсарлан, мөн бусад суралцагч үүнийг хэвийн зүйл хэмээн хүлээн авах, мөн төгсөгчийн ирээдүйг баталгаатай, амьдрах чадварт суулгаж буй олон сайхан талуудыг бий болгож буй явдал юм

СУРАЛЦАГЧДЫН ХӨГЖИЛД ӨНГӨ НӨЛӨӨЛӨХ НЬ



ОВОГ: НАМСРАЙ
НЭР: САРУУЛ

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

СУИС-н харъяа Дүрслэх Урлагийн Дээд Сургуулийн Монументаль уран зургийн ангийг УГЗ, зураач Ц. Нарангэрэл урланд суралцан төгссөн. Чимэглэх зураач мэргэжилтэй.

АЖЛЫН ТУРШЛАГА:

2002-2003 онд БНСУ-н “Sandoll comnicion” ХХК-д үсэг зохиогч
2003 оноос ҮҮПК-д “Чимэглэх урлагийн багш”


МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: “Тэргүүлэх”

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

2016 онд БСШУЯ-ны —“Боловсролын тэргүүн”
2019 онд ХНХЯ-ны “Жуух бичиг”

ЦАХИМ ХАЯГ: Saruul.bagsh@gmail,.com

Биднийг баясгаж бас уйтгарлуулж чаддагаараа хараагаар хүртэх бүх мэдрэмжээс хамгийн хүчтэй сэтгэл хөдөлгөдөг нь өнгө юм. Иймээс өнгө бидний дотоод сэтгэлийн илэрхийлэл болдог ажээ. Өнгө нь хүнд харагдаж буй мэдрэмж бөгөөд гэрлийн спектр, хүний нүдэн дэх гэрэл мэдрэгч эстэй харилцан үйлчлэлээр өнгө үүсдэг.



Уран зурагт өнгө хязгааргүй ертөнц, уран бүтээлчийн дотоод илэрхийлэл, давтагдашгүй мэдрэмж. Иймд аливаа нэгэн өнгө нь хүний сэтгэхүйн үйлчлэлд харилцан адилгүй нөлөөлж, гоо зүйн ертөнцийг бэлэглэдэг.

Өнгө бол олон талаар сэтгэл зүйд нөлөөлдөг чухал зүйл билээ. Уран зургийн болон урлагийн бүтээл туурвигч нь өнгөний талаар нарийн мэдлэг, мэдрэмжтэй байвал сайн бүтээл бий болох үндэс юм. Урлагийн чиглэлээр суралцаж эхэлж буй оюутнуудыг эхлээд заавал өнгийн задаргаа хийдэг. Уг хичээлийн зайлшгүй зурах Өнгийн тойрог. Өнгийн дараалал, шилжилт хувирал, хүйтэн дулаан өнгийн ялгаа. Өнгө найруулга зэргийн энэ хичээлээр олж авна.

Өнгө нөлөөлөлийг мэдсэнээр:

1. Өнгөний тухай цогц мэдлэгтэй болно.
2. Өнгөний сонголт баялаг болно
3. Өнгөөр гэрэл сүүдэр, хэлбэр орон зай гаргана.
4. Зурж буй зургийн өнгийг сэдэв, агуулгад тохируулна
5. Аливаа зүйлийг нэг талаас харахгүй болно
6. Юмсын хувирал, өөрчлөлтийг гаргаж сурна
7. Уран бүтээлийг ойлгож, хүндэтгэнэ, хайрлаж хамгаална.

ӨНГӨ бол сэтгэлийн толь билээ. Суралцагсдынхаа ертөнцийг гэрэл гэгээтэй, баялаг өнгөтэй болгон, урлагийн гоо сайхныг мэдрэн, суралцаж, авьяас билгээ нээн хөгжүүлэн, цаашдаа Дүрслэх урлагийн салбарт тодорхой байр суурь эзэлсэн уран бүтээлчид болоход нь бахархаж, уран бүтээлүүдийг нь үзэж, ертөнцийг бүтээх өнгө, өнгөний гайхамшигийг харах нь миний зорилго билээ.

Урлагийн мэргэжлийн багш гэлтгүй бусад төрлийн багш нар ч мөн өнгөний ач холбогдлыг сайтар судлан хичээл сургалт болон анги танхимдаа ашиглах нь зүйтэй. Бид өөрсдөө ч анзааралгүй өдөр тутамдаа таалагдсан, таатай харагддаг өнгөө хэрэглэсээр байдаг.



НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛД МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

ОВОГ: ГАНААСҮРЭН

НЭР: ЭНХ- АМГАЛАН

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

-1997 онд УБИС-Физик технологи-Физик
технологич /Бакалавр/

-2002 онд ЗГ-ын Хэрэгжүүлэгч агентлаг
Удирдлагын академи Төрийн
удирдлагын менежер

-2015 онд ШУТИС-КТМС- Мэдээллийн системийн
менежмент/ Магистр /

АЖЛЫН ТУРШЛАГА:

-1997-2001 онд Өвөрхангай Арвайхээр Соёмбо
цогцолбор сургууль багш

-2002-2009 онд Өвөрхангай аймгийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурал Хурлын ажилтан, Мэдээллийн төвийн
менежер

-2012 — 2015 онд ШУТИС ОМССХ МСҮТ-багш

-2015 оноос УУПК багш /6 дахь жилдээ/

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: “Заах аргач”

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

ХНХЯ-ны “Жуух бичиг” 2019 он

ЦАХИМ ХАЯГ: enkhee.mika@gmail.com

Дэлхий нийтийн боловсролын системийн үзэл баримтлалд Насан туршийн боловсролын асуудал чухлаар тавигдаж байна. Насан туршийн боловсролыг хэрхэн эзэмшүүлэх талаар багш Г.Энх-Амгалангын судалгааг танилцуулья.

Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангасан мэргэжилтэн бэлтгэхэд насан туршийн боловсрол олгож байгаа суурь бааз, технологи дээрээ тулгуурлан мэргэжлийн боловсролын салбарт инновацийг нэвтрүүлэх, цаашлаад мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагын сургалтын ажлын үр дүнг бизнесийн салбарт нэвтрүүлэх замаар хамтдаа хөгжих боломжтой.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын сургалтын үр өгөөжийг иргэдэд хүртээжтэй, хөдөлмөрийн зах зээлийн бодит хэрэгцээнд нийцсэн байдлаар хүргэх арга замыг эрэлхийлэн энэхүү судалгаа ажлыг эхлүүлсэн юм. Ингэхдээ ажил олгогч бизнесийн байгууллага, сургалтын байгууллага хоёр хамтарч хэрэгжүүлэх нь зүйтэй юм гэсэн санааг гаргахыг зорилоо.

ИРГЭДИЙН НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛД МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ОРУУЛАХ САНАЛ

- Хамтын ажиллагааны чиглэлийг зөв тодорхойлох
- Хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход байгууллагын стратегийг онцлог байдлыг харгалзах
- Сургалтын байгууллагыг тухайн салбарын мэдээллээр хангах
- Урт хугацааны харилцаа тогтоох
- Нээлттэй,байнгынн харилцааг бий болгох

НЭН ТЭРГҮҮНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ

- Сургуулиудыг нэгтгэж төрөлжүүлэх.
- Нээлттэй виртуаль сургууль байгуулж турших
- Мэдээллийн цахим санг буй болгож,үндэсний мэдээллийн нэгдсэн санд холбох
- Эзэмшсэн чадамжийг баталгаажуулдаг,хүлээн зөвшөөрдөг стандарт боловсруулж, үнэлж гэрчилгээ,үнэмлэх олгодог болох
- Төгсөгч бүрийн мэргэшлийн ур чадварыг үнэлж,түүнд тулгуурлан ажлын байртай холбох
- Аж ахуйн нэгж,байгууллага,дадлагажуулагч багшийг урамшуулах эдийн засгийн хөшүүргийг илүү бодитой болгох
- Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

Мэргэжлийн боловсролын байгууллагын зүгээс	Бизнесийн байгууллагын зүгээс	Насан туршийн боловсролд суралцагчийн зүгээс
Сургалтын чанар сайжирна.	Технологийн хамгийн сүүлийн ололтыг эзэмших	Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцна
Санхүүгийн эх үүсвэр, сан байгуулах боломж нэмэгдэнэ.	Лаборатори ашиглах боломжтой	Хэрэгцээт сургалтын материалыг олж авна
Туршилт, практикийн болон бусад мэдээллийн эх үүсвэр нэмэгдэнэ.	Боловсон хүчин брдүүлэх зардал хэмнэнэ.	Мэдлэг чадвараа үнэлүүлэн үнэмлэх, сертификаттай болно
Төрийн дарамт, хараат байдал арилна.	Суурь судалгааны эрсдлийг хуваалцана.	Өөрийн нөхцөл боломж, хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөрөө сонгоно.
Нэр хүнд өснө	Урт хугацааны судалгааны төсөл хэрэгжүүлэх	Олж авсан чадвараа үнэлүүлэн дэвших боломж гарна
Төгсөгчдийн ажлын байрны асуудал шийдэгдэнэ.	Хүний нөөц бүрдүүлэх суваг бий болно. Үр ашгийг дээшлүүлнэ.	Шаардлагатай чадварт хөрвөх чадвартай болно.

ҮСЧИН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫГ АЛСЫН ЗАЙН СУРГАЛТААР ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУРШЛАГА ҮР ДҮН



ОВОГ: БУЯНТӨР

НЭР: ЧУЛУУН - ЭРДЭНЭ

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

2009 онд Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж

Гоо засал, нүүр будгийн технологич мэргэжлээр /Бакалавр/

МУБИС-н ДУТС-г Техник технологи - Боловсрол

судлалын /Магистр/

АЖЛЫН ТУРШЛАГА:

-2009-2010 онд ҮУПК-д Үсчин гоо заслын багш

-2011-2012 онд Япон улсад Дадлагажигч

-2013-2019 онд ҮУПК-д Үсчний багш

-2019-2020 онд Самюүк МСҮТ-д багш

-2020 оноос ҮУПК-д Үсчин мэргэжлийн багшаар

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: “Заах аргач”
ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

- 2004 оны Алтан хайч-Эмэгтэй үс заслын
төрөл II байр

-2005 оны Уран чавхдас-Эмэгтэй үс заслын
төрөл III байр

-2006 оны БЗД-н ҮГЗ-н аварга
шалгаруулах тэмцээн-Гоо засалчийн
төрөл II байр

-“Улаанбаатар 2009” тэмцээнд Эмэгтэй
тайралт төрөл тусгай байр

ЦАХИМ ХАЯГ: Chuluunerdene8889@gmail.com

ҮҮПК-ийн Үсчин мэргэжлийн хичээлийг алсын зайн сургалтаар амжилттай зохион байгуулахад сэдвийн гол зорилго оршино. МС-ын хичээлийг ЧСС-ын арга зүйгээр зохион байгуулахдаа нийт суралцагчдад хүртээмжтэй, амжилттай хичээлийг явуулах явдал юм.

- Иймээс ижил мэргэжил олгож буй МСҮТ-ийн үсчин мэргэжлийн ЧН: Үс будах хичээлийг
- ЧСС-аар хэрхэн зохион байгуулж байсан тухай судлах, SWOT-шинжилгээ хийх.
- ҮҮПК-ийн үсчин мэргэжлийн ЧН: Үс будах хичээлтэй харьцуулан дүн шинжилгээ хийх
- Үсчин мэргэжлийн ЧН: Үс будах хичээлийг зайны сургалтаар зохион байгуулахад тохиолдож буй хүндрэл бэрхшээлүүд, түүнээс гарах арга замыг эрэлхийлэх
- ЧСС-нь суралцагч мэдлэг төвтэй сургалтаар биш чадвар төвтэй сургалтаар чиглэдэг.
- Мэргэжлийн хичээлийг нарийн төлөвлөж суралцагч нэг бүрийг хамруулах.
- Хичээлийг тайлбар хийж богино хугацаанд үр ашигтай заах.
- Цахимаар дадлага хичээлийг заах явцад тохиолдож буй бэрхшээлийг илрүүлж хэрэгжүүлэх боломжийг олж харсан практик ач холбогдолтой

ЧН:Үс будах хичээл зохион байгуулсан хэлбэр	2019-2020 хичээлийн жилийн хичээл явуулсан хэлбэр	2020-2021 хичээлийн жилийн хичээл явуулсан хэлбэр
	МСҮТ-н Үсчин 1, жилийн анги	ҮҮПК-н Үсчин 1, 2,5 жилийн анги
Лекц, семинар хичээл	PPT	PPT, Зурган хэлбэр, технологийн карт
Дадлага хичээл	Видео, Youtube Facebook	Видео, Youtube, Zoom, google meet, facebook, цахим сургууль
Цахимаар заах арга	Тараах материал, цахимаар өгч	Тараах материал, харилцан ярилцах, үзүүлэн таниулах, практик аргаар

ХИЧЭЭЛ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХИЙХДЭЭ

Багшийн хичээл боловсруулалт:

1. Хичээл төлөвлөхдөө суралцагчийн сурах 3-н хэв маяг:
Сонсголын сурах хэв маяг
Харааны сурах хэв маяг
Хөдөлгөөний (хүртэхүйн) сурах хэв маягийг анхаарч төлөвлөсөн.
2. Хичээлийн тайлбарлахдаа оновчтой үг хэллэг ашиглах.
3. Үйлдлийн дараалал харуулах.
4. Видео хичээлийг тайлбартай оруулах

Суралцагч сурах үйл явц:

1. Суралцагчийн сурах аргад тохируулан
2. Зурагт технологийн картыг зурж, бичиж, тэмдэглэх
3. Технологийн картыг хараад даган дууриаж хийх
4. Бичлэг хараад биетээр хийж сурах
5. Google meet, zoom харлцан ярилцаж хичээлийг явуулах

- Суралцагч бүрийн суралцах хэв маяг тохирсон сургалтын бүтээлч шинж чанартай хичээлийг төлөвлөх.
- Хичээл үзэж судлах, даалгавар өгөх хугацааг уян хатан болгох
- Багш хичээлээ зохион байгуулахдаа хичээл хоорондын уялдааг анхаарч зураг, видео хичээлийг тайлбартай оруулах.
- Видео хичээлийг богино хугацаанд оновчтой тайлбартай үзүүлэх
- Багш суралцагчдад урьдчилан мэдэгдэж хичээлийг шууд холбогдож заах.
- Zoom, google meet гм программ ашиглах.
- Үнэлгээний төлөвлөгөөг хичээлийн онцлогт тохируулан цахим хэлбэрээр (google forms, socrative гм) боловсруулж үнэлгээг зохион байгуулах
- Дээрх зүйлсийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд багш бүр дараах ур чадвараа тасралтгүй сайжруулах хэрэгтэй

- Сурган заах арга зүйн үндсэн мэдлэг
- Цахим хичээл боловсруулах мэдлэг ур чадвар
- Компьютер болон гадаад хэлний мэдлэг, илтгэх ур чадвар...гм

ОЁДЛЫН МЭРГЭЖЛИЙН ДАДЛАГЫН ХИЧЭЭЛИЙГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ҮР ДҮНТЭЙ ЯВУУЛАХ БОЛОМЖИЙГ СУДЛАХ НЬ



Оёдлын мэргэжлийн дадлагын хичээлийг цахим орчинд зохион байгуулсан туршлага үр дүнг танилцуулж байна

ОВОГ: ГОНЧИГДОРЖ
НЭР: ЖАРГАЛСАЙХАН

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

ШУТИС-ийн ҮТДСургууль, Оёмол бүтээгдхүүний технологич инженер

АЖЛЫН ТУРШЛАГА:

- Монголжингоо ГСДС-д 1жил
- 2000 оноос ҮУПК-д “Оёдлын багш”

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: “Заах аргач” **ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:**

- Хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан
- Боловсролын тэргүүний ажилтан

ЦАХИМ ХАЯГ: gjagaa77@gmail.com

Мэдээллийг хэрхэн боловсруулах заавар зөвлөмжийг хүргэснээр мэдээллийг хэрэглэх чадварт нөлөө үзүүлж байна уу? гэдгийг судлахаар ОБО1а,ОБО1б ангийн сурагчдад

Бүсэлхийн хувцасны үлгэр гаргах ЧН-р лабораторын ажлын зааврыг

- Ажлын зорилго
- Онолын хэсэг
- Гүйцэтгэх ажлын дараалал / зорилт / гэсэн агуулгатайгаар бэлтгэж хүргэсэн.

Лабораторын ажлын заавараа маш тодорхой болгох хэрэгтэй бөгөөд хийх ажлыг жишээчлэн тайлбарлаж оруулбал илүү үр дүнтэй болох нь тогтоогдсон.

Жишээлбэл: Хүний биеэс хэмжээг аваарай гэхийн оронд энэ хүснэгтийн дагуу хэмжээг авч оруулаарай гэх нь илүү системтэй хийх ажил тодорхой болж өгч байна.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ОНОВЧТОЙ ХОСЛОЛЫГ СУРГАЛТАД АШИГЛАХ ЗАРИМ АРГАЧЛАЛ

Лабораторын ажил №1

Нэг хажлагатай хагалаа халаас оёх

Ажлын зорилго: Нэг хажлагатай хагалаа халаас оёх технологи дарааллыг судалж, нэг хажлагатай хагалаа халаас оёх

Онолын үндэслэл

Халаасны төрөл ангилал, хагалаа халаас оёх технологи дарааллыг аль оновчтой хэлбэрээр оруулж өгөх

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДАРААЛАЛ

1. Онолын хэсгийг судалж, тэмдэглэл хөтлөх
2. Zoom апп программ ашиглан цахим хичээлд оролцох
3. Цахим хичээлээр халаасыг цаасаар хийх
4. Даавуу материал дээр бие даан онолын хэсэгт оруулсан дарааллыг баримтлан халаасыг гараар оёх
5. Зүсэлтийн схемийг зурах
6. Хийх явцад гарсан хүндрэл, учир шалтгааныг тоочин дүгнэлт бичих
7. Хийсэн бүтээлүүдээ баримтжуулан багш руу илгээх

ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

- МТ-ыг ашиглан онлайн сургалтыг тасралтгүй үр дүнтэй зохион байгуулж болох юм байна. Үүнд багш нар 60-70% бэлтгэлтэй байна.
- Цахим сургалтын үед сурагчдыг зөв чиглүүлж чадвал ур чадвар эзэмшилтийн хувь 20-25%-р өсөж болох нь.
- Сурагчдын сурах идэвх, сонирхол дээшилж, тэдний мэдээллийн хэрэгсэлтэй ажиллах чадвар, бие даан суралцах чадвар 100% нэмэгдэж байна
- Багш нарын хичээлийн бэлтгэл чанаржиж ЧН бүрээр гарын авлагатай, цахим мэдээллийн сантай болж байна
- Лабораторын ажлуудыг боловсруулснаар цахим сургалтын үед сурагчид бие даан ашиглах сургалтын хэрэглэгдэхүүнтэй болох юм байна.
- Идэвхитэй сорилтод тулгуурласан сургалтыг аргыг цахим сургалтын үед ашиглах нь илүү үр дүнтэй байна.
- Цаашид лабораторын зааврыг хэвлэж сурагчдад урьдчилан тараах хэрэгтэй байна
- Лабораторын зааварт хавсралт байдлаар эсгэгдэх бүрдэл хэсгүүдийг шууд авч ашиглаж болохуйц материалаар хийж оруулбал бүр үр дүнтэй болох нь ажиглагдаж байна.
- Багш бүр өөрийн сургалтын онцлогт тохирсон МТ-ыг хэрэглэх, цахим сургалтандаа анализ хийж ажиллах
- Лабораторын зааврыг боловсруулж сургалтандаа ашиглах
- Лабораторын зааврын хавсралтанд эсгэгдэх бүрдэл хэсгүүдийг оруулж өгөх / Оёдлын багш нарт хамаатай / гэсэн санаануудыг дэвшүүлж байна.

ҮЙЛДВЭР СУРГАЛТЫН ХИЧЭЭЛД ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭГЧДИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ НЬ



Ажил олгогч, үндэсний үйлдвэрлэгчдийг мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах арга замыг тодорхойлсон судалгааны ажлыг танилцуулж байна.

ОВОГ: ПУНЦАГ

НЭР: МӨНХЖАРГАЛ

ТӨГССӨН СУРГУУЛЬ:

1999 – 2001 онд ҮУПК /гоо заслын технологич /

2012-2014 онд СИТИ дээд сургууль “Арьс гоо засал, нүүр будгийн технологич”

АЖЛЫН ТУРШЛАГА:

1995-2005 онд “Гоемсог ” салон-д Гоо сайханч

2000 оноос ҮУПК багш

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

2000 онд “Шилдэг залуу” алтан медаль

2005 онд Заах аргач

2006 онд Багшийн алдар

2008 онд Шилдэг технологич багш

2009 онд Боловсролын яамны хүндэт жуух

2010 онд “Багшийн гавьяа”

2014 онд “Боловсролын тэргүүн”

ЦАХИМ ХАЯГ: Puntsagmunkhjargal1@gmail.com

Хөгжил-Хамтын ажиллагаа нь тухайн сургуулийг нийгэмд тодорхойлох гол хэмжүүр, хөшүүрэг, түлхэц болж өгөх ба зөвхөн сургалтын хөтөлбөрт анхаарах биш харилцагч байгууллагын санал,хөрөнгө оруулалт дэмжлэгийг авсанаар ажил олгогчдын эрэлтийг хангаад зогсохгүй зах зээлд хөрвөх тогтвор суурьтай хөгжих боломж гарцыг олгодоогоороо онцлогтой гэдэг нь бусад улс орнуудын хөгжсөн зам,амжилтуудаар нэгэнт нотлогдож байна. Иймээс бид хөгжлийн төлөө харилцагчидтайгаа зөвхөн үйлдвэрлэлийн дадлагын ажлын хүрээнд бус харилцан ашигтай ажиллаж уялдаа холбоогоо сайжруулах,хичээл сургалтын хөтөлбөр хэрэгжилтэнд татан оролцуулах, дадлага хичээлд хэрэглэгдэх материалыг хангуулах,хамтын ажиллагаагаа олон талт хэлбэрээр өргөжүүлэх хэрэгтэй байгаа юм. Иймээс үйлдвэр сургалтын хичээлийн явц чанарын талаар өндөр хөгжилтэй орнуудын хичээлийн хэрэгжүүлэх үйл явц ,үйлдвэрлэгчдын оролцоог судлан ,өөрийн орны үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа цар хүрээг гоо заслын мэргэжлээр жишээ аван судлаж тодорхойлохоор судалгаа хийсэн болно.

Сүүлийн жилүүдэд байгалийн гаралтай цэвэр түүхий эдээр хийсэн,хаягдалгүй,100 хувийн органик цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниуд бий болж,2018 оны байдлаар Монгол улсад гоо сайхны салбарт бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрх бүхий 30 орчим компани үйл ажиллагаа явуулж байна. Өнөөгийн байдлаар Монгол улсын 40 гаруй стандартуудыг (MNS) мөрдөж байгаас 75.6 хувь нь 2010 оноос өмнө батлагджээ. Монгол улсын хэмжээнд 2019-2020 оны байдлаар 8.0 тэрбум төгрөгийн гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрсэн бөгөөд жил жилд бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч байна. Сүүлийн 5 жилийн дундажаар бүтээгдэхүүний үйлдвэрлэл жил бүр 21 хувиар өсч,бүтээгдэхүүний үйлдвэрлэл төдийгүй бүтээгдэхүүний нэр төрөл олширч байна. Манай сургууль гоо сайханы мэргэжлээр нэг жилдээ дунджаар 120-150 хүүхэд сургадаг .



Жилийн материалын зардалд зөвхөн гоо сайханы мэргэжлээр дунджаар 6,000,000- 8,000,000 сая төгрөг зарцуулдаг тоо баримт байдаг. Гэтэл эдгээр бүтээгдэхүүний 60-70 хувийг тос,тосон бүтээгдэхүүн цэвэрлэгч бэлдмэлүүд эзэлдэг.Тэгвэл энэ байдлыг багасгах төсөвт хэмнэлт хийх,оюутануудад материалыг хүртээмжтэй болгох,гарц олох,нөөц боломжоо ашиглах зорилгоор энэхүү судалгааг хийж байна.

Жишээ: Материал түүхий эдийн жагсаалт: (Арьс арчлах хичээлийн 1 өдрийн зардал 1 хүүхдээр)

№	Материал, түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	Нэг суралцагчид ноогдох тоо хэмжээ	Хэрэглэх материалын үнэ	Нийт үнэ
1.	Мешил цэвэрлэгч	гр	30 гр	2500	2500
2.	Сүүн цэвэрлэгч	гр	15 гр	2000	2000
3.	Гүн цэвэрлэгч скраб	Гр	15гр	1800	1800
4.	Хөөсөн цэвэрлэгч	гр	10 гр	1500	1500
5.	Массаж тос	гр	50 гр	1200	1200
6.	Маска	гр	50 гр	2600	2600
ДҮН				11,600 төгрөг	

ҮЙЛДВЭРЛЭГЧ-МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА /ЯПОН УЛС/

Япон мэргэжлийн сургууль нь хувийн хэвшлийн сургуулийг бодвол өртөг арай бага боловч улсын сургуульд ороход шаардлага шалгуур өндөр байдаг. Мөн улсын сургуультай хамтарч ажиллахын тулд байгууллагууд өрсөлддөг. Хамгийн сайн хариуцлагатай байгууллага үйлдвэрлэл нь сургуультай хамтарч ажиллахаар сонгогддог. Сонгогдсон үйлдвэрлэгчид тус сургуулийн сургалтын материалын хангамжийг хариуцна. Мөн төгсөгчдийг ажлын байраар хангах болон төгсөгчдөд өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүний хэрэглэгч болсон байдаг тул үйлдвэрлэлийн ирээдүйг ханган ийм сонголт хийдэг байна.



ХУВЬ ХҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ, ХӨГЖИЛ



Хүн бүр өөрийн оршихуй халдашгүй ертөнцтэй байх ба өөрөө өөрийгөө танин мэдэх, нээж өөрчлөх замаар хөгжлийн эрх чөлөөг олно. Хүн өөрийгөө өөрчлөх болон боловсруулах явцад түүний амьдралд хандах хандлага төлөвшинө. Суралцагчдыг хэрхэн зөв хандлагатай болгох талаарх судалгааны ажлыг танилцуулж байна.



ОВОГ: БАТБОЛД
НЭР: БАТСҮРЭН
ТӨГССӨН СУРГУУЛЬ:

1998-2002 онд “Тэнгэр” дээд сургууль, Түүх-Нийгмийн ухааны багш

АЖЛЫН ТУРШЛАГА:

- Сэлэнгэ аймаг Сайхан сум Хөтөл ЕБС-д ТНУ-ны багш, нийгмийн ажилтан
- Төв аймаг Жаргалант сум ЕБС -д сургалтын менежер
- Сонгинохайрхан дүүрэг 104-р сургууль Нийгмийн ухааны багш
- “Сэнлизэ” сургууль Нийгмийн ажилтан
- 2019 оноос ҮҮПК-д Түүх нийгмийн ухааны багш

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ: 2018 онд БСШУСЯ-ны жуух бичиг

ЦАХИМ ХАЯГ: batboldbatsuren26@gmail.com

Германы нэрт сурган хүмүүжүүлэгч: Бернхард Бубе эрх чөлөө, сахилга батын талаар өнөө үед ямар үзэл баримтлалтай байгааг иш татая.

Тэрээр “Юу дуртайгаа хийж хүссэнээрээ байх, эрх чөлөөтэй байхыг хүүхэд, залуус болгон мөрөөддөг. Тэд Ямар ч нэг заавар хориглолтгүй, дүрэм журамгүй тийм л амьдралыг хүсч байдаг. Эрх чөлөө бол төлөв байдал биш харин урт удаан хөгжлийн хожмын үр шим нь өөрийгөө даван туулах хязгааргүй тэмцлийн эцэст сахилга батаас бие даах чадвар болон хувирсан тэр цагт л бий болдог. Эрх чөлөөт байдал гэдэг нь зөвхөн хэнээс ч хамааралгүй байх төдий бус, энэ нь өөртөө тодорхой зорилгоо ёс зүйн тодорхой үнэт зүйлд нийцүүлэн өөрийн амьдралаа тохируулж тууштай мөрдлөг болгож ажиллаж чадаж чадах тэр хүсэл чадварыг хэлнэ. Эрх чөлөөг сахилга батын хүчээр л олж авна.

Өнөөдөр өндөр хөгжилтэй, хөгжиж байгаа орнуудад ч хүүхэд залуучуудын хандлагын асуудал маш их хурцаар тавигддаг болсон. Тухайлбал:

- Нийгмийн илэрхий хангалуун амьдрал
- Мөнгөний ноёрхол
- Телевиз, цахим орчны дайралт
- Хүмүүжүүлэх соёлоо мартсан
- Хэт аминч үзэл
- Нийгмийн орчны буруу үлгэрлэл зэргийг давж

Хүүхэд залууст хүн чанарыг дээдэлсэн, ахан дүүсэг, эрх чөлөө, тэгш эрх, хүнийг хайрлах, шудрага ёс зэрэг үнэт зүйлсийг эрхэмлэдэг иргэн болгон хүмүүжүүлэхэд маш их анхааран ажилладаг болсон.



БАГШИЙН АЖИГАЛТЫН ХУУДАС						
№	Сурагчийн овог, нэр	Шалгуур				
		Хүнлэг	Мөхөө	Тархал	Донлог	Тундэг
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						

БАГШИЙН ОНОШЛОХ ХУУДАС			
Анги Бүлэг		Суралцагчийн овог	
№	Шалгуур	Үнэлгээ	
		Тийм /мэдэг/	Үгүй /мэдэхгүй/
1	Аав, ээжээ хүндэлдэг		
2	Багша хүндэлдэг		
3	Өглөө бүр мэндэлдэг		
4	Найз нохдолтойгоо эвтэй		
5	Бусдал санаачлагаараа тусалдаг		
6	Найз нохдоо хүндэлдэг		


ЗӨВЛӨМЖ

-Энгийн хий гомдол сэтгэлийн тавгүйтэл, айдас ичингүйрэл, итгэлгүй байдал, уур хилэн, гомдол тунирхал зэрэг сөрөг сэтгэл хөдлөл “Бидний тархинд” их хэмжээний зай талбай эзэлж суурьшсан бөгөөд тэдгээрийг зайлуулж, амар амгалан, аз жаргал, эрх чөлөөг суурьшуулахад хэцүү гэдгийг бид бие сэтгэлээрээ мэдэрч амьдарч байна.

-Сөрөг мэдрэмжийг зайлуулж, амар амгаланг авчрах нь чухал гэж мэдэж байгаа боловч хийж чадахгүй байх нь их л ороо бусгаа, ойлгоход бэрх мэдрэмж юм. Таагүй мэдрэмжийн ихэнхи нь бидний хамгийн хайртай дотны хүмүүстэй холбоотой байдаг.

- Сэтгэлийн таагүй мэдрэмжинд “ЗӨВХӨН ӨНӨӨДӨР” гэдэг зарчим баримтлах хэрэгтэй бөгөөд эдгээр таагүй түүх дурсамжийг уучилж өөрийгөө чөлөөлөх нь эдгэрэл энэ бүхэнд цаг хугацаа хэрэгтэй

ONLINE TESTING



ЦАХИМ ТЕСТЭЭР СУРАЛЦАГЧДЫН МЭДЛЭГИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн өнөө үед суралцагчдын мэдлэгийг үнэлэх тохирсон арга хэрэгслийг хайх, турших шаардлага багш бүрийн өмнө тулгарч байна. Энэхүү асуудлыг хөл хорионы үед цахимаар сургалт явуулж буй сургалтын байгууллагууд (ЕБС, Их дээд сургуулиуд, МСҮТ, ЭЕШ-ийн шалгалт) Google form программаар шийдвэрлэж байна. Иймээс энэхүү программыг Н.Ундрэм багш сургалтандаа ашиглаж байгаа туршлагыг танилцуулж байна



ОВОГ: НАРАНЦЭЦЭГ

НЭР: УНДРАМ

ТӨГССӨН СУРГУУЛЬ: 2001-2005 онд Монгол Улсын Боловсролын
Их сургуулийн Физик компьютерын багш

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2006 онд “Техник технологийн коллеж” -д компьютерын багш
- 2007 онд “Гурван-Эрдэнэ” багшийн дээд сургууль компьютерын багш
- 2007 оноос ҮҮПК —д “Мэдээллийн технологийн багш”

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ: “ЗААХАРГАЧ”

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

- Тэргүүний залуу Алтан медаль
- ХНХЯ-ы “Жуух бичиг” 2016 онд
- Мэдээлэл технологийн газрын “Хүндэт жуух”

ЦАХИМ ХАЯГ: undramtn@gmail.com

Бүх шатны сургалтын байгууллагийн үйл ажиллагаа цахим хэлбэртшилжсэн өнөө үед суралцагчдын мэдлэгийг үнэлэх тохирсон арга хэрэгсэлийг хайх, турших шаардлага багш бүрийн өмнө тулгарч байна. Тест, санал асуулга, судалгааг, зориулалтын хэрэгсэл ашиглан онлайнаар олуулаа хамтран зохиомжлох, асуулгыг зорилтот хэрэглэгчдэд орон зайнаас үл хамааран хялбархан хүргэх, мэдээллийг түргэн шуурхай цуглуулах, шинжлэх хэрэгцээ шаардлага өнөөгийн нөхцөл байдалд багш, сургалтын мэргэжилтнүүд, судлаач, маркетеруудын өмнө тулгарч байна. Энэхүү асуудалыг хөл хорионы үед цахимаар сургалт явуулж буй сургалтын байгууллагууд (ЕБС, Их дээд сургуулиуд, МСҮТ, ЭЕШ-ийн шалгалт) Google form програмаар шийдвэрлэж байна. Иймээс энэхүү програмыг сургалтандаа туршин хэрэгжүүлж байгаа болно.

АЧ ХОЛБОГДОЛ

Google Forms програмыг ашиглаж суралцагчдын онолыг мэдлэгийг шалгах нь дараах ач холбогдолтой болно.

-Шалгалтын материал гэж олон цаас үрэхгүй байгальд ээлтэй технологи

-Цаг хугацаа хэмнэнэ

-Суралцагч цаг хугацаа орон зайнаас үл хамааран мэдлэгээ үнэлүүлэх боломж бүрдэнэ

-Суралцагч ашиглахад хялбар гар утаснаасаа ч шалгалтаа өгөх боломжтой

-Суралцагч өөрийн тестийг хэрхэн хийсэнээ өөрийн gmail-д авах боломжтой

-Шалгалт эхлэх цаг болон дуусах цагийг тохируулах боломжтой



-Тусгай сервер шаардахгүй google drive ашиглан мэдээлэлээ хадгалдаг

-Тестийн үр дүнг суралцагч тус бүр болон нийтээр нь дүгнэж анализ хийх боломжтой


-Тестийн үр дүнг хүснэгт болон график хэлбэрээр үзэх

-Тестийг хамтран боловсруулж мөн үр дүнг хянах боломжтой


ӨӨРИЙН ЗААДАГ ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН ТЕСТИЙГ БОЛОВСРУУЛАН СУРАЛЦАГЧДЫН ХАМРАХ ХҮРЭЭГ ХАРУУЛАВ.




Windows орч...




Алгоритм пр...




Цахим супра...




Гарчиггүй ма...




Монгол хэл




Мэдээлэл зү...




Photoshop хи...



Компьютер х...



Веб мастер ...




Мэдээллийн ...


СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Ангийн нэр


96 хариулт



Ухаалаг утас ашигладаг уу




Онлайн тест бөглөхөд бэрхшээл байсан уу



Гэртээ цахим хичээл болон даалгавруудыг хийх компьютер байгаа юу?

96 хариулт



ДҮГНЭЛТ

Орчин цагт ухаалаг утсыг суралцагчдын 90-ээс дээш хувь нь хэрэглэж байна. Ухаалаг утсыг ашиглахад заавал gmail хаягтай байх шаардлагатай байдаг иймд цахим сургалтын үед суралцагчдын онолын мэдлэг үнэлэхдээ google form ашиглах нь илүү хүртэмжтэй байна. Энэ онлайн програмыг ашиглан гар утаснаас нь тестийн асуулгаа зохиож тохируулан суралцагчдад хүргэх боломжтой тул багш нарын ашиглах боломж их. Тестийг хамтран эзэмших боломжтой тул сургалтын алба багштай хамтран тестийн үр дүнг хянах, анализ хийх боломжтой болно. Тестийн үр дүнг хүснэгтээр маш хурдан хөрвүүлэн авч тест ажилласан суралцагчдын мэдээллийн нэгтгэн авах боломжтой юм.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ САНАА

Google form програмыг судлан сургалтандаа ашигласнаар дараах 2 санааг дэвшүүлж байна.

1. Манай сургууль нь МСҮТ, ПК-уудаас анхдагч болж өөрсдөө цахим сургуулийн системээ сургалтанд нэвтрүүлж чадсан билээ. Одоохондоо систем маань ажилд ороод удаагүй байгаа болохоор тестийн асуулгын төрөл цөөхөн байгаа билээ. Иймд google form-ийн асуулгын төрөл, боломжуудыг судлан шалгалтын хэсгийг хөгжүүлэх
2. Google form програмаар шалгалт авах үед суралцагчдыг онлайн уулзалтын програм болох zoom, google meet програмуудаас сонгож ажиллах шаардлага тавих, ингэснээр багш суралцагчийн тестийг ажиллах явцыг хянах боломжтой.



СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЭХЛЭЛ, ЦАХИМ НИЙТЛЭЛИЙН АНХНЫ БҮТЭЭЛИЙН УРИАЛГА:

Эрдэм судлалын бүтээлүүдийн эхлэл нь мэргэн байж, цаашид хичээл сургалт, үйлдвэрлэлд шинэ санаа, оновчтой бүтээлийг дэлгэрүүлэн хөгжүүлэх их үйлсэд хамт олноороо мэргэших болтугай.

2020 оны эрдэм шинжилгээний бага хурлын шилдэг 15 илтгэлийг та бүхэнд танилцууллаа. 2021 он судалгаа, шинжилгээний ажлыг өрнүүлсэн их бүтээлийн жил болно гэдэгт итгэж байна.

САНААЧИЛАН БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР

Б.МЯДАГБАДАМ, БАГШ ГАНЦАЦРАЛ

ХЯНАСАН: ЗАХИРАЛ Д.БУЯНДЭЛГЭР

ЭХ БЭЛТГЭСЭН: Д.НИНЖБАДГАР

ЭНЭХҮҮ СЭТГҮҮЛ УЛИРАЛД ТУТАМ 1 УДАА ГАРНА



@rajivgandhicolleges



info@pas.mn



www.pas.mn